



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 12 сарын 21 өдөр

Дугаар 754

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.4.1, 6.4.2, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Геронтологийн үндэсний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 11 нэрийн, нийт 17,548,496.77 (арван долоон сая таван зуун дөчин найман мянга дөрвөн зуун ерэн зургаан төгрөг далан долоон мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Төгсдэлгэр, Геронтологийн үндэсний төвийн ерөнхий захирал Р.Хишигжаргал нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө акталж данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 12 дугаар сарын 21 ны/ний өдрийн
759 дугаар тогтоолын хавсралт

ГЕРОНТОЛОГИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
АКТАЛЖ ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Актлах хөрөнгийн нэрс	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ (ширхэг)	Нэг бүрийн балансын үнэ (төгрөг)	Балансын нийт үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)
1	Агааржуулагч	12/23/2015	1	3,725,149.77	3,725,149.77
2	Плетка	9/28/2011	1	580,000.00	580,000.00
3	Dell дэлгэц HD7470	8/12/2013	1	269,900.00	269,900.00
4	Халдваргүйтгэлийн бодисын	1/20/2014	1	6,462,500.00	6,462,500.00
5	Үйлдвэр эмнэлгийн	1/20/2014	1	1,251,525.00	1,251,525.00
6	Аппарат Корона	10/13/2014	2	144,500.00	289,000.00
7	Шарлагын аппарат Имфрарекс	10/13/2014	2	82,600.00	165,200.00
8	УВЧ-30,00 аппарат НАНЭМА	10/13/2014	1	2,256,800.00	2,256,800.00
9	Дуслын шахуурга	8/5/2014	1	2,258,365.00	2,258,365.00
10	хувцасны шүүгээ	12/21/2020	1	28,422.00	28,422.00
11	Принтер1150	5/1/2010	1	261,635.00	261,635.00
НИЙТ ДҮН			13	17,321,396.77	17,548,496.77
					(арван долоон сая таван зуун дөчин найман мянга дөрвөн зуун ерэн зургаан төгрөг далан долоон мөнгө)